

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Даланзадгад зорчигч тээвэр ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/04/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2024 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533539 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533539 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Азуре хүлүг аудит ХХК Утас:70110090 Цахим хаяг:audit@azure.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ДАЛАНЗАДГАД ЗОРЧИГЧ ТЭЭВЭР
ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ЭНХБОЛД ТАНАА

2024.03.15 № 248
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Даланзадгад зорчигч тээвэр ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Даланзадгад зорчигч тээвэр ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгө, бараа материалын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нийгмийн даатгал, татварын тайлантай холбоотой 89,287.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 85,073.6 мянган төгрөгөөр өндөр бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дахь заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орлогыг 577,300.8 мянга, зардлыг 749,255.3 мянга, 92,919.5 мянган төгрөгийн ашигтай байхаар баталж, гүйцэтгэлээр 1,283,533.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн 804,252.1 мянган төгрөг зарцуулж 479,280.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 600,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг бүртгэлд тусгасан байна.

016020448

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 95.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	26,718,393.56	467,373.93
1.1.2	Дансны авлага	17,525,000.00	-
1.1.4	Бусад авлага	1,082,546.03	-
1.1.6	Бараа материал	19,638,338.72	57,417,861.83
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	64,964,278.31	57,885,235.76
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	424,072,987.51	910,433,206.63
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	424,072,987.51	910,433,206.63
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	489,037,265.82	968,318,442.39
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	302,874,471.55	302,874,471.55
2.1.2.2	Нөөц /урт хугацаат өр төлбөр/	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	302,874,471.55	302,874,471.55
2.2	Өр төлбөрийн нийт дүн	302,874,471.55	302,874,471.55
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	403,560,000.00	403,560,000.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(217,397,205.73)	261,883,970.84
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	186,162,794.27	665,443,970.84
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	489,037,265.82	968,318,442.39

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх үе	Тайлант үе
01	Борлуулалтын орлого /цэвэр/	328,510,863.04	125,813,443.83
02	Борлуулалтын өртөг	296,080,533.89	89,979,723.00
03	Нийт ашиг (алдагдал)	32,430,329.16	35,833,720.83
08	Бусад орлого	-	1,157,719,571.00
09	Борлуулалт, маркетингийн зардал	821,541.03	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	93,767,163.91	714,272,315.26
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(30,761,207.12)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(92,919,582.90)	479,280,976.57
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(92,919,582.90)	479,280,976.57
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(92,919,582.90)	479,280,976.57
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Бусад олз (гарз)	-	-
25	Орлогын нийт дүн	(92,919,582.90)	479,280,976.57
26	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	403,560,000.00	(156,891,412.33)	246,668,587.67
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	32,413,789.76	32,413,789.76
3	Залруулсан үлдэгдэл	403,560,000.00	(124,477,622.57)	279,082,377.43
4	Тайлант үеийн цэвэр (алдагдал)	-	(92,919,582.90)	(92,919,582.90)
5	2022 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	403,560,000.00	(217,397,205.73)	186,162,794.27
6	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
7	Залруулсан үлдэгдэл	403,560,000.00	(217,397,205.73)	186,162,794.27
8	Тайлант үеийн цэвэр ашиг	-	479,280,976.57	479,280,976.57
9	2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	403,560,000.00	261,883,770.84	665,443,770.84

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант үе
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2	Мөнгөн орлогын дүн(+)	365,192,729.30	544,053,443.83
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	299,097,772.80	125,813,443.83
4	Буцаан авсан албан татвар	661,025.00	-
5	Татаас санхүүжилтийн орлого	-	418,240,000.00
6	Бусад мөнгөн орлого	65,433,931.00	-
7	Мөнгөн зарлагын дүн(-)	344,155,567.55	570,304,463.46
8	Ажиллагчдад төлсөн	154,247,903.61	222,899,232.47
9	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	41,235,613.82	60,555,449.44
10	Бараа материал худалдан авахад төлсөн	25,185,780.00	37,283,550.00
11	Ашиглалтын зардалд төлсөн	28,223,630.67	32,111,467.23
12	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	24,387,000.00	112,813,523.00
13	Татварын байгууллагад төлсөн	9,144,726.45	17,195,116.32
14	Даатгалын төлбөрт төлсөн	3,366,775.00	8,110,150.00
15	Бусад мөнгөн зарлага	58,364,138.00	79,335,975.00
16	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	21,037,161.74	26,251,019.63
17	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
18	Мөнгөн орлогын дүн(+)	3,698,007.90	-
19	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
20	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	3,698,007.90	-
21	Мөнгөн зарлагын дүн(-)	12,959,500.00	-
22	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,959,500.00	-
23	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,261,492.10)	-
24	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	11,775,669.65	26,251,019.63
25	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,942,724.17	26,718,393.56
26	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,718,393.56	467,373.93

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

д/д	Орлого зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
1	Үйл ажиллагааны борлуулалтын орлого	52,300,800.00	125,813,444.00	(73,512,644.00)
2	ОНХСангаас авах нөхөн олговор /Зорилтот бүлгийн /	400,000,000.00	418,240,000.00	(18,240,000.00)
3	Замын постын орлого	72,000,000.00	-	72,000,000.00
4	Бусад орлого	53,000,000.00	739,479,571.00	(686,479,571.00)
5	Нийт борлуулалтын орлого	577,300,800.00	1,283,533,015.00	(706,232,215.00)
6	Нийт цалин хөлс	305,400,000.00	159,670,661.41	145,729,338.59
7	Хоолны хөнгөлөлт	73,080,000.00	68,040,000.00	5,040,000.00
8	ЭМД-НДШ-ын зардал	47,310,000.00	38,264,523.00	9,045,477.00
9	Бичиг хэргийн зардал	2,418,000.00	4,442,950.59	(2,024,950.59)
11	Шатахууны зардал	65,969,520.00	73,548,273.00	(7,578,753.00)
12	Шуудан холбооны зардал	1,042,800.00	1,042,800.00	-
13	Цахилгааны зардал	31,422,944.00	32,120,467.23	(697,523.23)
14	Цэвэр бохир ус	545,520.00	545,520.00	-
15	Засвар үйлчилгээний зардал	-	20,952,549.70	(20,952,549.70)
16	Цэвэрлэгээ хог хаягдлын зардал	326,000.00	904,100.00	(578,100.00)
17	Урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	-
18	Аюулгүй ажиллагаа гал хөдөлмөр хамгаалал	2,000,000.00	3,000,000.00	(1,000,000.00)
19	Амь даатгал	449,680.00	449,680.00	-
20	Тээврийн хэрэгслийн сэлбэг дугуйн зардал	20,320,000.00	59,534,494.26	(39,214,494.26)
21	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,605,000.00	9,605,000.00	(8,000,000.00)
22	Тээврийн хэрэгслийн даатгал	9,034,750.00	47,120,467.23	(38,085,717.23)
23	Тээврийн хэрэгслийн татвар зам ашиглалт, агаарын бохирдол	730,000.00	8,430,000.00	(7,700,000.00)
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	1,325,000.00	9,325,000.00	(8,000,000.00)
25	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	13,540,000.00	13,540,000.00	-
26	Банкны үйлчилгээний хураамж	96,000.00	96,000.00	-
27	Нийт зардал	577,115,214.00	551,132,686.00	25,982,727.58
28	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	172,140,141.00	253,119,351.88	(80,979,210.88)
29	Нийт үйл ажиллагааны зардал	749,255,355.00	804,252,037.88	(54,996,682.88)
30	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	(92,919,583.00)	479,280,976.57	386,361,393.57

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 588,374.6 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 508,219.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 80,155.1 мянган төгрөгийн алдаанд зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд орлогын дүнг ангилал буруу бүртгэсэн нь НББОУС 1 болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 418,240.0 мянган төгрөгөөр залруулав.
- Орлогын дэлгэрэнгүй тайланд зарлагын дүнг ангилал буруу бүртгэсэн нь НББОУС 1 болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 89,979.5 мянган төгрөгөөр залруулав.

Аудитаар нийт 9,132.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 390.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,300.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 7,442.8 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн зарлагын ажил гүйлгээг анхан шатны баримт руу тулган шалгахад баримтын иж бүрдэл дутуу болон төлбөрийн баримтгүй 8,136.4 мянган төгрөгийн 15 ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.	1	8,136.4	-	-	-	-	-	-	1	8,136.4	1	8,136.4
Бараа материалын дансны 71,950.7 мянган төгрөгийн 74 ажил гүйлгээ нь тамгаар баталгаажаагүй, 68.0 мянган төгрөгийн орлогын баримтын хөл дүн зөрүүтэй байна.	1	72,018.7	-	-	-	-	-	-	1	72,018.7	1	72,018.7
Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 3,894.9 мянган төгрөгийн 6 хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	-	-	-	-	-	-	-	1	-	1	-
Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор 20060101 кодтой дэлл зөөврийн компьютер хөрөнгө эвдрэлтэй ашиглах боломжгүй нөхцөл байдалтай байсан.	1	-	-	-	-	-	-	-	1	-	1	-

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Урт хугацаат зээлийн дансанд бүртгэлтэй 302,874.4 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	-	-	-	-	-	-	-	1	-	1	-
Орлогын дэлгэрэнгүй тайланд ерөнхий удирдлагын зардлын дүнг илүү дүнгээр тусгаж, ангилал буруу бүртгэсэн байна.	1	89,979.5	-	-	1	89,979.5	1	89,979.5	-	-	-	-
Орлогын дэлгэрэнгүй тайланд борлуулалтын орлогын дүнг илүү дүнгээр тусгаж, ангилал буруу бүртгэсэн байна.	1	418,240.0	-	-	1	418,240.0	1	418,240.0	-	-	-	-
Дүн	7	588,374.6	-	-	2	508,219.5	2	508,219.5	5	80,155.1	5	80,155.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүй 390.0 мянган төгрөгийн урамшууллыг байгууллагын удирдлагад олгосон байна.	1	390.0	1	390.0	-	-	-	-	-	-	-	-
Орон сууцанд амьдардаг ажилтанд 1,300.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний дэмжлэг олгосон байна.	1	1,300.0	-	-	1	1,300.0	-	-	-	-	-	-
Нийгмийн даатгалын тайланг хувь хүний орлогын албан татварын тайлантай тулган шалгахад 7,442.8 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	1	7,442.8	-	-	-	-	1	7,442.8	-	-	-	-
Дүн	3	9,132.8	1	390.0	1	1,300.0	1	7,442.8	-	-	-	-

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.